



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Хот орчмын аяллын маршрут тогтоох,
судалгаа хийх тухай

Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.4.5, Аялал жуулчлалын тухай хуулийн 16-р зүйлийн 16.1.14, тус газрын дүрмийн 2.3, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хот орчмын бүсэд явган аяллын маршрут тогтоох судалгаа хийх ажлыг “Эрүүл Монгол” клуб, Аялал Жуулчлалын Багш Судлаачдын Нийгэмлэг, “Монголын Газарзүй-Аялал Жуулчлалын Холбоо” ТББ зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Хот орчмын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн /Б.Ербахыт/-д даалгасугай

2. Хот орчмын бүсэд аяллын маршрут тогтоох судалгаа хийх ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, судалгааны ажил зохион байгуулах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


Тус ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах төсөв 345.210 /гурван зуун дөчин таван мянга хоёр зуун арав/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2013 оны 11 сарын 11-ны өдрийн 15 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ХОТ ОРЧИМД АЯЛЛЫН МАРШРУТ ТОГТООХ, СУДАЛГААНЫ АЖЛЫН УДИРДАМЖ

ЗОРИЛГО:

Хот орчимд буюу Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан ууланд явган аяллын маршрутыг тогтоох, судалгаа хийх

ХУГАЦАА:

2013 оны 11-р сарын 12-ны өдрөөс 11-р сарын 18-ны өдрийн хооронд зохион байгуулна.

СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Хот орчимд явган аяллын чиглэл тогтоох ажилд Уланбаатар хотыг сайн мэдэх уулчин, эрдэмтэн судлаач нарыг хамруулна. Үүнд:

Баянзүрх ууланд явган аяллын маршрут тогтоох баг

- Олон улсын хэмжээний мастер, “Эрүүл Монгол” клубыг үүсгэн байгуулагч Б.Цэвээндаш
 - Нийслэлийн Аялал Жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Ербахыт

Чингэлтэй ууланд явган аяллын маршрут тогтоох баг

- МУБИС-ийн Спорт явган аяллын багш Д.Батболд
 - Нийслэлийн Аялал Жуулчлалын газрын мэргэжилтэн Н.Алтанзаяа

Сонгинохайрхан ууланд явган аяллын маршрут тогтоох баг

- Монголын Газарзүй-Аялал Жуулчлалын Холбоо ТББ-ийн гүйцэтгэх захирал, Уулын спортын мэргэжлийн хөтөч Ч.Мөнгөншагай
 - Нийслэлийн Аялал Жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Жаргалан

ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ:

Судалгааны ажил зохион байгуулахад шаардагдах тээврийн хөлс, солбилцол тодорхойлогч багаж түрээслэх, бичиг хэргийн болон бусад зардлуудыг газрын холбогдох зардлаас гаргана

ХҮРЭХ ҮР ДҮН:

Уг судалгаагаар хот орчимд явган аяллын 4-6 чиглэлийг шинээр тогтоох бөгөөд тогтоосон чиглэлийн дагуу тэмдэгжүүлэх, амрах цэгүүдийн тохижуулах ажлыг хийх боломжтой болно.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 20.12.2011. сарын 11.-ны өдрийн
жоот тушаалын хоёрдугаар хавсралт



**ХОТ ОРЧИМД ЯВГАН АЯЛЛЫН ЧИГЛЭЛИЙГ ТОГТООХ,
СУДАЛГААНЫ АЖЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ /Төгрөгөөр/
1	Тээврийн хөлс	33л	1,620	53,460
2	Солбилцол тодорхойлох багаж түрээслэх	6 ширхэг	30,000	180,000
3	Уулын аяллын хамгаалалтын багаж түрээслэх	9 хүнд	7,500	67,500
3	Бичиг хэргийн зардал			44,250
	Нийт төсөв			345,210